

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ГЛОБАЛ ЧИГ ХАНДЛАГА

Д.Алтайхүү¹, Д.Хишигжаргал¹, Л.Мөнхчулуун¹, Л.Отгонтөгс², Л.ОюунЭрдэнэ²

¹АШУУИС-ийн ДУА дахь АУС-ын СШУТэнхим

²АШУУИС-ийн ДУА дахь АУС-ын Сувилахуйн Тэнхим
altaikhuu@mnumns.edu.mn

Хураангуй

XXI зуунд дээд боловсролын системд бий болсон голлох глобал чиг хандлагыг оюутнуудын өсөлт, интернационалчлах үйл явц, МХТ-ийн хөгжилд тулгуурлан авч үзлээ. Энэ өгүүлэлд ДБСБ-д суралцагчдын өсөлтийг авч үзэхийн зэрэгцээ даяарчлалыг дээд боловсролын салбарт нөлөөлж буй үзэгдэл, харин дээд боловсролын интернационалчлалыг даяарчлалын улмаас үүсч буй боломж, асуудлуудад дээд боловсролын зүгээс үзүүлж буй хариу үйлдэл бөгөөд эргээд тэрээр хэрхэн даяарчлалд нөлөөлж байгааг тодруулахыг зорилгоо.

Түүнчлэн МХТ-ын хөгжил, боловсролын үйлчилгээний зах зээл хэрхэн харилцан бие биенээ нөхцөлдүүлж, харилцан хамаарал нь улам гүнзгийрч байгаа болон аливаа улс орны дээд боловсролын зах зээл зөвхөн үндэсний хэмжээний бус олон улсын хэмжээний хурц өрсөлдөөнт систем рүү улам хүчтэй татагдан орж, харин дээд боловсролын дэлхийн зах зээл улам өргөжих хандлагатай байна гэсэн санааг дүгнэн гаргаж байна.

Түлхүүр үгс: даяарчлал, дээд боловсролын зах зээл, оюутнуудын өсөлт, интернационалчлал, дээд боловсролын түгээмэлжилт.

Оршил

Даяарчлал бол дээд боловсролын эдийн засаг, нийгэм, улс төр, соёлын үр дагаварыг агуулж буй олон талт үйл явц хэдий ч орчин үеийн боловсрол бол даяарчлалын үйл явц дахь нийт улс үндэсний болон хүн төрөлхтний үнэт зүйлс болохын хувьд даяарчлалын үйл явцад нөлөөлж байна.

Даяарчлалын нөлөө, шалтгаан, шинж чанар, үр дагаварыг хамарч буй мэтгэлцээн нь мэдээж төгсгөлгүй мэт зөрчилдөөнт шинжийг агуулж буй хэдий ч маш чухал ач холбогдолтой (Запругаев, С.А. и др 2007. 18) болж байна.

Даяарчлал нь “Технологи, эдийн засаг, мэдлэг, үнэт зүйлс, үзэл санааны... хил дамжин тархсан ... урсгал. Тэрээр тухайн үндэстэн бүрийн уламжлал, соёл, нөөц баялаг, приоритетийн түүхээс хамааран улс орон бүхэнд өөр өөрөөр нөлөөлж (Knight.J., Dewit.H. 1997. 84)” байгаа ба энэхүү урсгалыг “хүн төрөлхтөн нэгэн бүхэл шинж рүү, амьдралын нэг хэв маяг руу адилсах үйл явц” (Бэгз.Н. 2012. 125), хүн төрөлхтөний хувь заяанд нөлөөлөгч нийтлэг хүчин зүйл гэж үзэхийн хэрээр улс орон, үндэстнүүдийн бие биенээсээ хамаарах бодит хамаарлал улам нэмэгдэж байна.

Гэхдээ ийм нөхцөл байдалд академич, доктор Н.Бэгзийн (2012. 128-129) үзэж байгаагаар ямар ч улс орны тэр тусмаа хөгжиж буй улс орны хувьд “даяаршлаас зайлсхийх бус харин шат дараатайгаар бүхий л алдаа, ашгийг тооцон үзсэний үндсэн дээр урагшлах илүү дөт зам”-ыг олох, улс орон бүхэн “дэлхий нийтийн боловсролын орон зайд бүрэн эрхтэйгээр оролцох”, тухайн ард түмний “аж төрөх ёс, соёл, сэтгэлгээний төлөв байдлыг хадгалан үлдэх” явдал нь чухал юм.

Тиймээс хөгжлийн глобал хандлагын гадна үлдэхгүйн тулд олон улсын түвшинд дээд боловсролын системд бий болж буй үйл явцыг судлах, ямар чиглэлээр үйл ажиллагаагаа төлөвлөх шаардлагатайг анхаарах нь чухал юм. XXI зуунд дээд боловсролын системд бий болсон голлох глобал чиг хандлагыг дараах байдлаар авч үзлээ. Үүнд:

- Оюутнуудын өсөлт
- Интернационалчлах үйл явцын өргөжилт
- МХТ-ийн хөгжил

Үндсэн хэсэг

Оюутнуудын өсөлт: 1900 оны эхэнд 500000 хүн их, дээд сургуульд суралцаж байсан (Schofer Eva, Meyer J. 2005. 898) бөгөөд 1950 гэхэд 6.3 сая болж нэмэгдсэн байна (Гьгьз Kemal, 2007, 45).

АНУ нь дээд боловсролыг олон нийтэд хүртээмжтэй болгох талаар анхны туршлагажсан улс (Philip G. Altbach., at al. 2009. 4) болсон бөгөөд европт дэлхийн 2-р дайны дараа шинжлэх ухааны дэвшил, техник, технологи, үйлдвэржилтийн өсөлт нь үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, амьжиргааны түвшинг дээшлүүлсэнээр дээд боловсрол эзэмшигчдын тоо нэмэгдсэн (UNESCO, 1967) байна.

Дээрх хүчин зүйлс нь ДБСБ-д суралцагчдын өсөлтөнд 1970 оны сүүлч хүртэлх хугацаанд ихээхэн дэмжлэг болж байсан бөгөөд сүүлийн жилүүдэд азийн орнуудад арай хожуу латин америкийн орнуудад эрчимтэй нөлөөлсөн юм.

1970-2000 оны хооронд оюутны өсөлт эрс нэмэгдсэн ба тоон үзүүлэлтээр авч үзвэл 28.6 саяаас 99.5 сая болж нь 248 %-иар өсчээ. RMIT их сургуулийн төлөвлөлт, судалгааны зөвлөх Анжел Калдероны (2012) тооцоолж байгаагаар 2000-2030 оны хугацаанд 99.5 саяаас 414.2 сая болж нь 314%-иар өснө (хүснэгт 1) гэж үзсэн байна.

Хүснэгт 1 Дээд боловсролын хамрагдалт (1970-2020), түүний төлөв байдал (2030-2035)

Жил	Хамрагдалтын тоо /саяаар/	Өсөлтийн хувь
1970	28,558	
1980	47,494	248%
1990	66,912	
2000	99,485	
2005	138,408	1730%
2010	171,603	
2020*	292,006*	
2030	412,196	314%
2035	522,526	

Эх сурвалж: UNESCO Institute for Statistics, annual Global Education Digests; author estimates for 2035

* Филип Дж.Альтбахын судалгаагаар

Ихэнх судлаачид 2034-2035 оны үед ДБСБ-д суралцагчдын тоо хагас тэрбум болно гэсэн урьдчилсан шинжилгээтэй (прогноз) санал нэгдсэн байна.

Тэдгээр судлаачдын нэг болох Бостон коллежийн олон улсын дээд боловсролын төвийн захирал, судлаач Филип Дж.Альтбахын (2015. 9) судалгаагаар оюутнуудын тоо 20 жилийн өмнөхөөс 2 дахин нэмэгдсэн бол харин 2020 он гэхэд 100 саяаар нэмэгдэх ба энэ өсөлтийн ихэнх нь Энэтхэг, Хятад улсуудад байх болно гэж үзсэн байна.

Зөвхөн АНУ-ийг авч үзвэл 1960-аад онд “дээд боловсролын насны хүн амын” 40 хувь нь дээд боловсролыг сонгож байсан бол дэлхий дахинд энэ хувь 2000-2007 онуудад 19 хувиас 26 хувь болтлоо өссөн бөгөөд энэ өсөлт нь дундаас дээших орлоготой болон их орлоготой орнуудад нэлээд хүчтэй өрнөж байна.

Дээд боловсролын хамрагдалтыг харуулах нэг арга бол 15-79 насны нийт хүн амд тухайн жилийн ДБСБ-д суралцагчдын эзлэх хувийг авч үзэх бөгөөд энэ нь 2000 онд 2.38 хувь байсан бол ЮНЕСКО-гийн албан ёсны статистик мэдээгээр 2009 онд 3.38 хувь болж өссөн байна. Харин тус өсөлт цаашид үргэлжлэх хандлагатай бөгөөд 2020 онд 41.1 хувиар (4.77), 2020-2030 онуудад буюу 10 жилийн хугацаанд 38.9 хувиар (6.63) өсөх төлөвтэй ба 2035 он гэхэд 8.68 хувьд хүрнэ гэсэн урьдчилсан шинжилгээ (прогноз) дэвшүүлсэн (UNESCO Institute for Statistics Population) нь дээд боловсрол улам түгээмэлжиж буй олон улсын хандлагын илрэл юм.

Оюутны тооны өсөлтөд нөлөөлж буй бас нэг чухал хүчин зүйл бол суралцагчдын насны өсөлт юм. Учир нь XX зууны дунд үе хүртэл их сургуулиудад олж авсан мэдлэг бол XX зууны эцэс болон XXI зууны эхэнд ажиллаж буй ажиллагсадын амьдралд хангалттай байсан боловч мэдлэгээ шинэчлэх хугацаа янз бүрийн чиглэлээр 2-3 жилээр буурсаар байна.

Хөгжингүй орнуудад ЕБС-ийг төгсөгчдийн 60 орчим хувь нь харин АНУ, Канадад бараг 80 гаруй хувь нь их, дээд сургуульд элсэн орж байна. Дэлхийн дээд боловсролын байгууллагуудын тоо 14 мянга гаруй болсон байна. Зарим улс орнууд бүх нийтийн дээд боловсрол руу тэмүүлж байна.

Энэ талаар UNESCO-ийн 2009 оны илтгэлд дэлгэрэнгүй авч үзсэн байдаг бөгөөд дээд боловсролын түгээмэлжих (massification) үзэгдэл нь аж үйлдвэржилтийн дараах эдийн засагт шилжиж буй үйл явц, мэдлэгийн эдийн засгаас шалтгаалсан гэж үзсэн байна.

Олон улсжих (интернационалчлах) үйл явц: Дээд боловсролын интернационалчлалын асуудлыг авч үзэхгүйгээр түүнд нөлөөлж буй даяаршлын нөлөөг авч үзэх боломжгүй юм. Энэ чиглэлээр судалгаа хийж буй судлаачдын бүтээлүүдэд дүн шинжилгээ хийхэд мөн чанартаа даяарчлал бол дээд боловсролд нөлөөлж буй чухал үзэгдэл, харин дээд боловсролын интернационалчлал бол даяарчлалын улмаас үүсч буй боломж, асуудлуудад дээд боловсролын зүгээс үзүүлж буй хариу үйлдлүүдийн нэг илрэл гэж үзэж байна.

Их сургуулиудын олон улсын холбооноос (IAU) 131 орны 1336 их дээд сургуулиуд буюу нийт сургуулиудын 20 хувийг хамруулан явуулсан 4-р глобалсудалгааны дүнг (ЭваЭгрон-Полак, 2014. 14) авч үзвэл их дээд сургуулийн интернационалчлал нь тэргүүлэх ач холбогдолтой гэж оролцогчдын 69 хувь нь, өмнөх гурван жилийн хугацаанд үнэ цэнэ хэвээр хадгалагдаж байна гэж 27 хувь нь, тус хугацаанд ач холбогдол нь өссөн гэж 30 хувь нь үзсэн бөгөөд, 75 хувь нь интернационалчлалын стратегитай буюу боловсруулж байгаа гэсэн бол 16 хувь нь сргуулийн стратегийн хүрээнд авч үзэх приоритетуудын нэг гэж үзсэн нь интернационалчлалын өсөн нэмэгдэж буй үүрэг, ач холбогдлыг баталж байна.

Мөн их дээд сургуулиудын 22 хувь нь багш, оюутан солилцоог, 21 хувь нь эрдэм шинжилгээний чадавхийг бэхжүүлэх, 18 хувь нь олон улсын нэр хүндээ нэмэгдүүлэх, 8 хувь нь сургалтын хөтөлбөрт инновацийг нэвтрүүлэх зорилго бүхий тусгай стратеги боловсруулж байна гэж хариулсан байна.

Бостон коллежийн олон улсын дээд боловсролын төвийн орлогч захирал Лора Рамблийн үзэж байгаагаар (2015. 8) XXI зууны үндсэн зорилт бол “ухаалаг интернационалчлал” бөгөөд дээд боловсролын салбар дахь түүний хэрэгцээ ойрын 20 жилд зайлшгүй бөгөөд чухал юм. Түүнчлэн “даяарчлалын хариу үйлдэл, боловсролын чанарыг сайжруулах стратеги, эсвэл үйл ажиллагааны бусад хүрээнд өрнөж буй өөрчлөлтийн хариу болох интернационалчлал нь сүүлийн жилүүдэд дээд боловсролд нөлөөлж буй хамгийн гайхалтай үзэгдлийн нэг юм” гэж онцолсон байна.

“Ухаалаг Интернационалчлал” нь судлаачид, гүйцэтгэгчид, стратегичид нарын хоорондын харилцаа, хамаарлыг өргөжүүлэхийг шаарддаг бөгөөд “...интернационалчлалыг хөгжүүлэх гэж л байгаа бол дараагийн хорин жилийн ярвигтай, тогтворгүй боловсролын орчинг тоймлох, зүг чигээ олохын тулд шинэ санаа, шинэ мэдээлэл, шинэ мэргэжлийн боловсролын хөтөлбөрт анхаарлаа хандуулах хэрэгтэй” (Лора Рамбли. 2015. 9) юм.

Хөгжиж буй улс орнуудын гол зорилго нь дээд боловсрол бараг бүх нийтэд хүртээмжтэй байхад чиглэгдэх хандлагатай байгаа бөгөөд бүхий л улс орныг хамарсан боловсролын экспорт буюу оюутан солилцоо өргөжиж буй үйл явц нь яах аргагүй анхаарал татсан асуудал болж байна.

Энэ зууны эхэн гэхэд гадаадад суралцсан хүмүүсийн тоо 1.9 сая байсан бол 2006 онд 2.9 сая болж, 2008 онд 3.3 сая (Rajika Bhandari and Raisa Belyavina. 2012. 14-15), ЭЗХАХБ-ын илтгэлд (Education at a Glance. 2012) 2000-2010 оны хооронд 99 хувиар (2.1-4.1 сая) нэмэгдсэн гэж дурдагсан бол ЮНЕСКО-гийн мэдээгээр зургаан жилийн хугацаанд (2004-2010) бараг 50 хувиар нэмэгдэж, 2014 онд 5 саяд (ICEF. 2014) хүрсэн байна

Англи хэлний өсөн нэмэгдэж буй хэрэгцээ:

Тус хэрэгцээ нь боловсролын экспортын өсөлтөд нөлөөлж буй хүчин зүйлийн нэг нь яах аргагүй мөн.

“Глобал хөгжлийн хандлага нь олон улсын харилцаа, хамтын ажиллагааг эрс түргэтгэж, дэлхийн хэмжээгээр нэгдмэл нэг хэл, мэдээллийн нэг систем, харилцааны нийтлэг зарчмыг бий болгож байгаа” (Бэгз.Н 2011, 208) өнөө үед тулгарч буй бэрхшээлүүдийн нэг нь хэлний бэрхшээл бөгөөд дээрх нийтлэг зарчмын гадна үлдэхгүйн тулд улс орон бүр боловсролын шинэчлэлийн хүрээнд эн тэргүүнд шахам англи хэлийг тавьж, тодорхой үе шаттайгаар шийдвэрлэж байна.

Дюссельдорфийн Их Сургуулийн судлаачид дэлхийн улс орнуудад аль хэл хамгийн түгээмэл байдгийг судалсан ба тэдний үзэж байгаар дэлхийн 101 орон англи хэлээр ярьж байгаагаас гадна англи хэлийг албан ёсны хэлээ болгосон 35 орон байна (CIA world factbook).

Олон улсын болон улс хоорондын гэрээ хэлэлцээр НҮБ-ын албан ёсны зургаан хэлний аль нэг дээр хийгддэг олон улсын дүрэм журам байдаг. Гэвч эдгээр хэлнүүдээс хамгийн их хүлээн зөвшөөрөгдсөн, бичмэл мэдээллийн агууламжаараа, техник технологи дахь хэл зүйн ноёрхлоороо англи хэл илт давамгайлж байна. XX зуунд шинжлэх ухааны байгууллагуудад олон улсын харилцааны хэл болохын хувьд англи хэлний үүрэг улам тодорхой болсон.

Дээд боловсролын олон улсжилт (интернационалчлал): Тус олон улсжих үйл явцыг дараах хүчин зүйлүүдийн үр дагавар гэж дүгнэж байна. Үүнд:

- Дэлхийн эдийн засаг дахь улс орнуудын өрсөлдөөн

- Инновацийн үйлдвэрлэл, технологийг хөгжүүлэх замаар өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхийн тулд өндөр ур чадвартай ажиллах хүчний төлөөх хоорондын өрсөлдөөн
- Дэлхийн зах зээлд байр сууриа бэхжүүлэх өрсөлдөөн
- Ажил олгогчдын эрэлт, бүс нутгийн инноваци хөгжилд нийцэхүйц боловсролын систем, түүний зах зээл бүрэлдэн буй үйл явц зэрэг болно.

Сүүлийн жилүүдэд судлаачид “интернационалчлал” ойлголт улам өргөжин, ач холбогдол нь гүнзгийрч байгааг чухалчилж байгаа бөгөөд тэрээр зөвхөн боловсролын салбарт төдийгүй бусад бүхий л салбаруудад өөрсдийн нөлөөгөө дэлхий, бүс нутгийн хэмжээнд өргөжүүлэх зорилгод чиглэсэн тухайн улсын боловсролын бодлогын нэг чухал элемент нь болж байна.

Их, дээд сургуулийн интернационалчлагдаж буй түвшинг тодорхойлоход эрдэм шинжилгээний үйл ажиллагаа болон сургалтын үйл явц хэрхэн интернационалчлагдаж буйг үнэлэх тоон үзүүлэлтүүдээс гадна чанарын үзүүлэлтүүд бас ордог бөгөөд энэ нь их чухалд тооцогддог. Үүнд:

- Их дээд сургуулиудын амжилтыг үнэлсэн гадаадын шинжээчдийн үнэлгээ
- Эргэх холбооны үр дүн болох төгсөгчдийн үнэлгээ
- Ажил олгогчдын зүгээс төгсөгчдөд өгөх үнэлгээ

Хөндлөнгийн шинжилгээний олон байгууллага, сүлжээнээс тогтоосон зэрэглэл нь их сургуулиудыг өөр хоорондоо сургалт, судалгааны гол гогцоо үзүүлэлтүүдээ жишиж үзэх, зэрэглэлийн жагсаалтанд байршсан зиндаагаа зөв мэдэрч, цаашид хэрэгжүүлэх тэргүүн ээлжийн асуудлаа оновчтой эрэмблэх бололцоог нээж өгдөг.

Нөгөө талаас маргаашийн суралцагчид болон тэдний гэр бүлийнхэнд суралцах сургуулиа сонгох болон ажил олгогчдод мэргэжлийн ижил түвшингээр төгсөж буй төгсөгчдийг сонгон шалгаруулахад тухайн зэрэглэл нь чухал мэдээлэл өгч байдаг.

Гадаадын авъяаслаг оюутнуудыг татах асуудалд онцгой ач холбогдол өгөхөөс гадна зэрэглэлийн байр суурь нь өндөр мэргэшсэн эрдэмтэд, оюуны элитүүдийг урьж ажиллуулах боломжийг олгодог байна.

Дээд боловсролын байгууллагын төсвийн санхүүжилт буурч буй нөхцөлд их сургуулиудын зэрэглэл нь төрийн зүгээс эхний ээлжинд санхүүжилтийн хэмжээг хадгалах, улмаар цаашид хэрхэн дэмжих хүсэл эрмэлзлэлийг нэмэгдүүлдэг.

Үүний нэг тодорхой илрэл гэвэл ОХУ-ын ерөнхийлөгчийн “Боловсрол болон шинжлэх ухааны салбарт баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд авах арга хэмжээний тухай” зарлигт (2012. 599) “2020 он гэхэд дэлхийн шилдэг 100 сургуулийн тоонд өөрийн орны таваас

доошгүй их сургуулийг оруулах"-аар (1.в) тусгасан бол "Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", "Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого 2014-2024" баримт бичгүүдэд "Монгол Улсын дөрвөөс доошгүй их сургуулийг Азийн шилдэг 100 их сургуулийн эгнээнд хүргэнэ" (7.13; 2.2.3) гэж зааснаас харж болох бөгөөд энэ нь төрөөс үзүүлэх дэмжлэг, баримталж буй стратегийг харуулж байна.

Мэдээлэл харилцааны технологийн хөгжил:

XXI зуун бол мэдээлэл, нанотехнологийн зуун гэж хүлээн зөвшөөрөгдсөн. Хүний үйл ажиллагааны бүхий л хүрээнд компьютер болон холбогдох тоног төхөөрөмжүүд өргөн нэвтэрч буйтай холбоотойгоор боловсрол дахь шинэ мэдээллийн технологи нь боловсролын тогтолцооны өмнө шинэ асуудлыг бий болгож улмаар шинэ хэтийн төлөв, ирээдүйг нээсэн.

Мэдээлэл харилцаа холбооны технологийг салбарын хөгжил, гүйцэтгэх үүрэг ач холбогдлын талаар дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч, НҮБ-аас "улс орон бүр МХХТ-ийг хөгжүүлэх талаар төрийн бодлогоо тодорхойлох, тус салбарын тогтолцоог боловсронгуй болгохыг" улс орнуудын төр засагт уриалсан байдаг.

Дэлхий даяар интернет хэрэглэгчдийн тоо 1995 онд 44,8 сая гаруй, 2000 онд 414.8 сая, 2005 онд 1 тэрбум, 2010 онд 2 тэрбум, 2015 онд 3.2 тэрбум гаруй давж байсан бол 2020 оны 7-р сарын байдлаар 4.7 тэрбум (Worldwide digital population as of July 2020) болж өссөн байна.

Шинэ зууны өнгөрсөн хугацаанд дэлхийн хүн амын тоо 6.1 тэрбумаас 7.8 тэрбум болж 1.3 дахин өссөн бол интернет хэрэглэгчдийн тоо 7.8 дахин өсч, хүн амын 60 орчим хувийг эзэлж байгаа нь өдөр тутмын амьдралын чухал бөгөөд салшгүй хэрэглээ болж, үнэ цэнэ нь нэмэгдсээр байгааг харуулж байгаа юм.

Мэдлэгийн үүсгүүр болон түүнийг түгээгчийн үүргийг гүйцэтгэгчийн хувьд нь дээд боловсролыг авч үзвэл тэрээр хөгжингүй болон хөгжиж буй орнуудын аль алины нь хувьд үндэсний хөгжлийн гол хөдөлгөгч хүч хэмээн хүлээн зөвшөөрдөг байна.

Мөн түүнчлэн үндэстэн дамнасан компани, хувийн байгууллага, хэвлэл мэдээллийн компани зэрэг боловсролын шинэ үйлчилгээ үзүүлэгчид төрөн гарч байгаа нь дээд боловсролын дэлхийн зах зээлийн өрсөлдөөнийг улам нэмэгдүүлж байна.

Дүгнэлт

Зардлаа олон дахин нөхөх хөрөнгө оруулалт, эдийн засгийн нэг салбар гэж үзэх дээд боловсролын түгээмэлжиж буй глобалчиг хандлага нь оюутнуудын өсөлт, интернационалчлах үйл явц, МХХТ-ийн хөгжлөөр голлон тодорхойлогдож байна.

Дээд боловсролын интернационалчлал бол даяаршлын улмаас үүсч буй боломж, асуудлуудад

өөрийн зүгээс үзүүлж буй хариу үйлдлүүдийн илрэл болж, эргээд даяарчлалд нөлөөлж байна.

МХТ-ын хөгжил нь боловсролын зах зээлийн өсөлтийн гол хүчин зүйл болж байгаа хэдий ч эргээд боловсролын үйлчилгээ нь түүний хөгжлийн гол түлхэц, түгээгүүрийн үүргийг гүйцэтгэж байна. Өөрөөр хэлбэл тэд харилцан бие биенээ нөхцөлдүүлж, тэдний харилцан хамаарал нь улам гүнзгийрч байна.

Дээд боловсрол бол зардлаа олон дахин нөхөх хөрөнгө оруулалт гэж үзэх хандлага түгээмэлжиж мөн аливаа улс орны дээд боловсролын зах зээл зөвхөн үндэсний хэмжээний бус олон улсын хэмжээний хурц өрсөлдөөнт систем рүү улам хүчтэй татагдан орохын хэрээр дээд боловсролын дэлхийн зах зээл улам өргөжих хандлагатай байна.

THE GLOBAL TENDENCY OF THE HIGHER EDUCATION MARKET

Abstract

We considered the main global trends in the system of higher education in the 21st century on the basis of the growing number of university students, the internationalization of higher education, the development of information and communication technology.

In this article, regarding as the growth in the number of students in the higher educational institutions, we tried to clarify the globalization is represented as a phenomenon that has influence on higher education, but the internationalization of higher education is interpreted as one of the manifestations of the higher educational reactions to the opportunities and problems thanks to globalization and influences back to the globalization.

And also we defined how the development of information and communication technology and the market of educational services are conditioned by mutually and deepening their correlation, and the market of higher education draws to the fierce competitive system, not only at the national level but also at the international level. But there is a tendency that the world market of higher education will be growth further.

Ашигласан материал:

1. Алтайхүү,Д. (2018). Монголын дээд боловсролын өсөлтийн байдал, түүнийг судалсан зарим үр дүн. Дисс, МУБИС. УБ, х.65-81
2. Алтайхүү,Д. (2018), Дээд боловсролын олон улсжих үйл явц, цаашдын хандлага. Боловсрол судлал, 7(145), х.3-10
3. Альтбах,Р., (2015) Массовизация высшего образования и глобальная экономика знаний: тянущиеся противоречия, Журнал "Международное Высшее Образование" №80. с. 8-10
4. Бэгз,Н., (2012) Боловсролын философи, УБ, х 125-129
5. Запругаев,С.А, и другие (2007) Глобализация и системы обеспечения качества высшего образования. М. МГУ. с 18-24Лора Рамбли.,

- (2015) Умная интернационализация-первоочередная задача XXI века. Международное высшее образование. №80. тал 8-14
6. Лора Рамбли., (2015) Умная интернационализация-первоочередная задача XXI века. Журн. Международное высшее образование. №80. с. 8-14
 7. ЭваЭгрон-Полак.,(2014)Интернационализация высшего образования, Журн, Международное высшее образование, №76, с. 14-16
 8. Гьгз Kemal., (2007) Quality Assurance in a Globalised Higher Education Environment: An historical perspective, Istanbul
 9. Philip G. Altbach., Liz Reisberg., Laura E. Rumbley. (2009) Trends in Global Higher Education: Tracking an Academic Revolution. A Report Prepared for the UNESCO. World Conference on Higher Education. 4
 - 10.Schofer Eva, Meyer,J., (2005) The Worldwide Expansion of Higher Education Worldwide, in American Sociological Review, Vol 70, Dec. pp 898-920
 - 11.Rajika Bhandari and Raisa Belyavina (2012) Global Student Mobility: Trends and New Directions International higher education – number 66 winter pages 14-15.
 - 12.ICEF. (2018) Summing up international student mobility in 2018,.
 - 13.Worldwide digital population as of July 2020. <https://www.statista.com/statistics/617136/digital-population-worldwide>